

## СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ДАДЛАГЫН ЖУРАМ<sup>1</sup>

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь сурган хүмүүжүүлэх дадлагыг зохион байгуулах, чанар үр дүнг нь үнэлэх, МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, түүний бүтцийн нэгжүүд, дадлагыг удирдах багш болон дадлагажигч оюутны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зорилготой.
- 1.2 Багшийн боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын нэг хэлбэр болох сурган хүмүүжүүлэх дадлага нь бусад сургалтын байгууллагад тодорхой хугацаанд багшлах үйл явц бөгөөд оюутан мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, дидактикийн хичээлүүдээр эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгаж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх арга зүйг эзэмшинэ.
- 1.3 Энэ журмын хүрээнд зохицуулагдахгүй бусад асуудал МУИС-ийн оюутны дадлагын ерөнхий журам, бусад дүрэм, журмаар зохицуулагдана.

### Хоёр. Дадлагын зохион байгуулалт

- 2.1 Сурган хүмүүжүүлэх дадлага нь бусад дадлагын нэгэн адил сургалтын төлөвлөгөөнд заавал судлах хичээл хэлбэрээр тусгагдан, сургалтын технологийн горимын дагуу мэргэжлийн тэнхим/профессорын багаас боловсруулж, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр батлуулсан дадлагын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдана.
- 2.2 Сурган хүмүүжүүлэх дадлагын нэг багц цагийн хэмжээ 16 долоо хоногтой улирлын хувьд 48 цагтай тэнцүү байна. Багш боловсролын стандартын дагуу сурган хүмүүжүүлэх дадлагын нийт багц цагийн хэмжээ 12 байх ба нэг удаагийн дадлагын багтаамж 6 багц цагаас хэтрэхгүй байхаар төлөвлөнө.
- 2.3 Сурган хүмүүжүүлэх дадлага дараах зорилтыг агуулна. Үүнд:
  - Суралцагчдын насны болон хувийн онцлогт тохируулан танин мэдэх үйл ажиллагааг удирдах, сургалтыг зохион байгуулах арга барилыг эзэмших,
  - Мэргэжлийн дидактик, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэгээ практикт бүтээлчээр хэрэглэх,
  - Сурган хүмүүжүүлэх ажил төлөвлөх чадвар эзэмших,
  - Сургалт, хүмүүжлийн ажилд дүн шинжилгээ хийх,
  - Судлан шинжлэх чадвараа хөгжүүлэх,
  - Хэл яриа, харилцааны соёл эзэмших,
  - Багшийн ёс зүйд суралцах.
- 2.4 Дадлагыг оюутны бүлгээр зохион байгуулахыг чухалчлах ба бүлгийн оюутны тоо 6-8 байна. Дадлага хүлээж авах байгууллагын онцлог, хүчин чадлаас хамааран ганцаарчилсан байдлаар хийхийг зөвшөөрнө.
- 2.5 МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба ЕБС-тай сурган хүмүүжүүлэх дадлагыг хамтран зохион байгуулах гэрээ байгуулж дадлагыг удирдах багш, дадлагажигч оюутны эрх, үүргийг тодотгон, баталгаажуулна. Оюутан ганцаарчлан дадлага хийх тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба, дадлагыг явуулах сургалтын байгууллага болон оюутны хооронд гурван талын гэрээ байгуулна.

### Гурав. Дадлага удирдах багшийн хүлээх үүрэг

- 3.1. МУИС-иас дадлага удирдах багш нар оюутныг тухайн сургуулийн дотоод дүрэм, журамтай танилцуулж, биеэ авч явах байдал, багшийн ёс зүйг баримтлах талаар зөвлөгөө өгч, сурган хүмүүжүүлэх дадлагын хөтөлбөрийг танилцуулна.

<sup>1</sup> Захирлын 2003/665 тоот тушаалаар баталсан журмын шинэчилсэн найруулга.

- 3.2. Мэргэжлийн тэнхим/профессорын багаас удирдах мэргэжлийн багш дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- Оюутанд онол, арга зүйн зөвлөгөө өгч, хичээлийн сэдэвчилсэн, календарчилсан төлөвлөгөө, нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөртэй танилцаж, батална.
  - Оюутан бүрийн зааж буй хичээлд сууж зөвлөгөө өгч, үнэлнэ.
  - Оюутны зааж буй хичээлийн хэлэлцүүлгийг хариуцаж, зохион байгуулна.
- 3.3 Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхмээс удирдах сурганы багш дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- Оюутны боловсруулсан сурган хүмүүжүүлэх дадлагын төлөвлөгөөтэй танилцаж, батална.
  - Сурагч болон хамт олныг судлах асуудлаар оюутанд онол, арга зүйн зөвлөгөө өгнө.
  - Хүмүүжлийн үзүүлэх ажлыг зохион байгуулахад зөвлөн тусалж, сэдэвт ажлын хэлэлцүүлгийг зохион байгуулна.
- 3.4 Тухайн дадлагыг зохион байгуулах сургуулиас томилогдсон багш дадлагын хөтөлбөрийн дагуу оюутныг удирдан, зөвлөн туслах, хяналт тавих үүрэг хүлээнэ.
- 3.5 Дадлага удирдсан багш нар оюутан бүрийн эцсийн тайлантай танилцаж, тайлан хамгаалуулах хурлыг хамтран зохион байгуулна.

#### **Дөрөв. Дадлагажигч оюутны хүлээх үүрэг**

- 4.1 Тодорхой шинжлэх ухааны үндэс, эрүүл мэндийн боловсрол, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал, сургалтын технологи, мэргэжлийн дидактикийн хичээлүүдийг амжилттай судалсан байна.
- 4.2. Боловсролын харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг судалж мэдсэн байна.
- 4.3. Дадлагын хугацаанд багшийн үүрэг гүйцэтгэнэ. 7 хоногт дүнтэй 1, дүнгүй 2 цагийн хичээл зааж, даасан ангийн сурагчдын дунд дадлагын хугацаанд 2-оос доошгүй удаа хүмүүжлийн ажил зохион байгуулна.
- 4.4. Дадлагын хугацаанд хийх ажлын төлөвлөгөө гарган, удирдагч багшаар батлуулна. Ажлын төлөвлөгөө дараах бүтэц, үлгэрчилсэн агуулгатай байх ба ажил бүрийн гүйцэтгэх хугацааг зааж, биелэлтийг тухай бүр дүгнэн бичнэ. Үүнд:
- А. Зохион байгуулалтын талаар:
- Дадлага хийх сургуулийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцах,
  - Дадлагын явцад зохион байгуулах хүмүүжлийн ажлын талаар санал асуулга явуулах, багшийн ажлын төлөвлөгөөтэй танилцах,
  - Танилцах өдөрлөг, үдэшлэг зохион байгуулах,
  - Даасан ангийн сурагчдын хөгжлийг ажиглан судлах, ангийн журналтай танилцах,
  - Мэргэжлийн заах аргын нэгдэл болон тухайн сургуулийн сургалт, хүмүүжлийн зорилготой үйл ажиллагаанд туслах.
- Б. Сургалтын талаар:
- Мэргэжлийн багшийн хичээлийн сургалтын хөтөлбөртэй танилцах,
  - Мэргэжлийн заах аргын нэгдэл, кабинетийн ажилтай танилцах,
  - Заах хичээлийн хуваарь гаргах,
  - Заах ээлжит хичээлийн хөтөлбөр бэлтгэх, хэрэв дүнтэй цаг бол хичээл орохоос нэг хоногийн өмнө багшаар заавал батлуулах,
  - Сургалтын хөтөлбөрийн дагуу дүнтэй ба дүнгүй хичээл заах,
  - Мэргэжлийн багшийн хичээлд сууж, туршлага судлах,
  - Бусад оюутны хичээлд сууж, дүн шинжилгээ хийх, хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо хуваалцах,
  - Давтлага (ганцаарчилсан, хэсэгчилсэн, нийтийг хамарсан) зохион байгуулах,
  - Үзүүлэн, тараах материал хийж, ашиглах,

- Сургалтанд техник хэрэгсэл ашиглах,
- Сурагчдын дэвтэр засах,
- Мэргэжлийн дагуу хичээлээс гадуурх ажил зохиох.

**В. Хүмүүжлийн ажлын талаар:**

- Сургуулийн хүмүүжлийн ажлын ерөнхий төлөвлөгөөтэй танилцах,
- Сургууль, ангийн хүмүүжлийн ажилд оролцох,
- Хүмүүжлийн үзүүлэх ажил (сэдэв, хугацаа, байраа тодорхой бичнэ) зохион явуулах,
- Хүмүүжлийн бусад ажил (уулзалт, үзвэр, аялал, тэмцээн гэх мэт) зохиох,
- Сурагчийн хамт олныг судалж, тодорхойлолт бичих,
- Сурагчдын хөгжил, төлөвшлийг судалж, тодорхойлолт бичих,
- Эцэг эхтэй хамтран ажиллах, эцэг эхийн хурал зохион байгуулах,
- Оюутны хүмүүжлийн бусад ажилд дүн шинжилгээ хийх.

**Тав. Дадлагын үнэлгээ**

- 5.1 Дадлага дуусахад оюутны тайлан, ЕБС-иас удирдсан багшийн тодорхойлолтыг үндэслэж, идэвх, хариуцлагыг харгалзан, оюутны дадлагын дүнг мэргэжлийн болон сурганы багш нар хамтран гаргана. Үүнд:
- Сургалтын ажлын үнэлгээ -50 оноо
  - Хүмүүжлийн ажлын үнэлгээ -30 оноо
  - Дадлагын хугацаан дахь идэвхи, чармайлт, хариуцлагын үнэлгээ -20 оноо байна.
- 5.2 Дадлага хийсэн оюутны дүнг нэгдсэн дүнгийн хуудсанд жагсааж, дадлага хийсэн сургууль, хугацааг бичиж, удирдсан багш нар гарын үсэг зурсан байна. Оюутны дадлагыг удирдсан мэргэжлийн багш оюутны авсан дүнг тайлан хамгаалалтаас хойш ажлын 5 хоногийн дотор сургалтын мэдээллийн системд оруулна.
- 5.3 Мэргэжлийн багш, сурганы багш нар “МУИС-ийн багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам”-д заасны дагуу ажлаа үнэлүүлэн, багц цаг тооцуулна.
- 5.4 Сурган хүмүүжүүлэх дадлагыг ЕБС-иас удирдсан багшид долоо хоногт оюутан бүрийн 3 цаг, удирдах ажилтнуудад (захирал, сургалтын менежер) мөн хугацаанд дадлагын оюутны нэг бүлэгт нийт 2 цаг тооцож МУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан багшид олгох цагийн хөлсний хэмжээг тогтоосон тарифаар ажлын хөлс олгоно.

## СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ДАДЛАГА ХИЙХ ГЭРЭЭ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Нэг талаас МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль болох \_\_\_\_\_, түүнийг төлөөлөн тус сургуулийн Сургалтын албаны эрхлэгч \_\_\_\_\_/цаашид “бүрэлдэхүүн сургууль” гэх/, нөгөө талаас \_\_\_\_\_-р сургууль, түүнийг төлөөлж захирал \_\_\_\_\_/цаашид “...-р сургууль” гэх/ нар нь оюутны сурган хүмүүжүүлэх дадлагыг зохион байгуулах зорилгоор энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Гэрээлэгч талууд боловсролын багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.
- 1.3. Сурган хүмүүжүүлэх дадлагатай холбоотой асуудлаарх талуудын оролцоо, үүрэг, хариуцлагыг энэхүү гэрээгээр зохицуулна.

### ХОЁР. МУИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 2.1. Сурган хүмүүжүүлэх дадлагыг сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй зохион байгуулна.
- 2.2. Тухайн сургуулийн сургалт, хүмүүжлийн ажилд оюутнуудаа идэвхтэй, зохион байгуулалттай оролцуулна.
- 2.3. Сургуулийн удирдлага дадлагыг удирдсан /ЕБС-ийн/ багшийн цагийн хөлсийг зохих журмын дагуу тооцон олгоно.

### ГУРАВ. \_\_\_\_-Р СУРГУУЛИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1. Дадлагажигч оюутанд сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулахад туслалцаа үзүүлж, дадлагажигч оюутныг ажлын цагаар сургууль дээр ажиллах нөхцөл бололцоогоор хангаж өгнө.
- 3.2. Сургалтын менежер, заах аргын нэгдлийн зүгээс дадлагын оюутнуудын хичээл заах төлөвлөгөө, хичээлийн нэгж хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөлгөө өгч, хяналт тавина.
- 3.3. Хүмүүжлийн ажлын дадлага эзэмшихэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

### ДӨРӨВ. УДИРДАХ БАГШИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 4.1. Багш сурган хүмүүжүүлэх ухаан, дидактик боловсруулалт хийх асуудлаар дадлагажигч оюутанд онол, арга зүйн зөвлөгөө өгч, хичээл зааж үзүүлнэ.
- 4.2. Оюутанд хичээлийн нэг хөтөлбөр боловсруулахад туслан зөвлөх ба боловсруулсан хөтөлбөрүүдийг батлана.
- 4.3. Оюутны хичээлд сууж, хэлэлцүүлэг хийлгэж, үнэлгээ өгнө.
- 4.4. Оюутны зааж буй хичээлийн хэлэлцүүлгийг хариуцаж, зохион байгуулна.

### ТАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 5.1. Дадлага шаардлага хангахгүй байна гэж бүрэлдэхүүн сургуулиас удирдаж буй багшийн үзсэн нь дадлагажигч оюутны дэмжлэгийг авбал гэрээг цуцлах тухай санал гаргаж болно. Ийнхүү гарсан саналыг ...-р сургуультай тохиролцож шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд дадлагыг удирдсан багшийн цагийн хөлс төлөгдөхгүй.

5.2 Дадлагажигч оюутны буруутай үйл ажиллагаанаас болж гэрээ цуцлагдсан тохиолдолд дадлагыг нөхөн хийлгэнэ.

### **ЗУРГАА. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ**

6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

### **ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:**

МУИС-ийн бүрэлдэхүүн \_\_\_\_\_

сургуулийн Сургалтын албаны эрхлэгч \_\_\_\_\_

/гарын үсэг: \_\_\_\_\_ /

Хаяг: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_ -р сургуулийн захирал \_\_\_\_\_

/гарын үсэг: \_\_\_\_\_ /

Хаяг: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Огноо: